



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/250

Мандалговь

Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай
зөвшөөрөл олгох, сунгах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.9, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.12.3, дэх заалт, эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох салбар комиссын 2020 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагуудад тусгай зөвшөөрлийг хавсралтад зааснаар олгосугай.

Хоёр. Эрүүл мэндийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Эмийн сангийн стандарт MNS5260:2015, Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц үйл, үйл ажиллагаа MNS5081:2013, өөрсдийн үйл ажиллагаанд холбогдох бусад стандартын хэрэгжилтийг хангаж ажиллахыг эмнэлэг, эмийн сангийн дарга нарт үүрэг болгосугай

Гурав. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгасан болон шинээр олгосон байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг тусгай зөвшөөрөл олгох салбар комисс (А.Нарантуяа)-д, Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Эрүүл мэндийн газар (Г.Бат-Орших) тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ ЭРДЭНЭ



482010631

Аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр
сарын 16-ны өдрийн 1650 дугаар
захирамжийн хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ БАЙГУУЛЛАГЫН
НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

№	Үүсгэн байгуулагчийн нэр	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар	Тусгай зөвшөө р-лийн хугацаа	Хугацаа
1	Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар	Баянжаргалан эрүүл мэндийн төв	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	ЭУ-15/10/988	5 жил	2021-01-29 2026-01-29
2	Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар	Хулд сумын эрүүл мэндийн төв	Эмнэлэг, сувилал бүх төрлийн мэргэжлийн үйл ажиллагаа	ЭУ-14/10/978	5 жил	2020-12-30 2025-12-30
3	Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар	Адаацаг сумын эрүүл мэндийн төв	Эмнэлэг, сувилал бүх төрлийн мэргэжлийн үйл ажиллагаа	ЭУ-14/10/975	5 жил	2020-12-30 2025-12-30
4	Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар	Гурвансайхан сумын эрүүл мэндийн төв	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	ЭУ-15/10/992	5 жил	2021-01-29 2026-01-29
5	Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар	Өлзийт сумын эрүүл мэндийн төв	Эмнэлэг, сувилал бүх төрлийн мэргэжлийн үйл ажиллагаа	ЭУ-14/10/977	5 жил	2020-12-30 2025-12-30
6	Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар	Цагаандэлгэр сумын эрүүл мэндийн төв	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	ЭУ-15/10/997	5 жил	2021-01-29 2026-01-29
7	Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар	Сайхан-Овоо сумын эрүүл мэндийн төв	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	ЭУ-15/10/996	5 жил	2021-01-29 2026-01-29
8	Орон нутгийн өмчит ААТҮГ	Говь-Угтаал сумын эм эргэлтийн сан	2-р зэрэглэлийн эмийн сан	ЭСХ-15/10/1007	3 жил	2020-04-25 2023-04-25
9	Орон нутгийн өмчит ААТҮГ	Хулд сумын эм эргэлтийн сан	2-р зэрэглэлийн эмийн сан	ЭСХ-15/10/1005	2 жил	2020-01-29 2022-01-29

10	Орон нутгийн өмчит ААТҮГ	Цагаандэлгэр сумын эм эргэлтийн сан	2-р зэрэглэлийн эмийн сан	ЭСХ-15/10/1009	2 жил	2020-01-29 2022-01-29
11	"Дундговь эм хангамж" ХХК	Эм ханган нийлүүлэх байгууллага	Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхит бүтээгдэхүүн ханган нийлүүлэх	ХХ-15/10/1022	3 жил	2020-06-03 2023-06-03
12	"Дундговь эм хангамж" ХХК	Эмийн сан	1-р зэрэглэлийн эмийн сан	ЭСХ-15/10/1027	3 жил	2020-07-09 2023-07-09
13	"Өсгө жирэм" ХХК	"Өсгө жирэм" хувийн эмийн сан	2-р зэрэглэлийн эмийн сан	ЭСХ-15/10/1029	5 жил	2020-07-29 2025-07-29
14	"Задьгранд" ХХК	"Мишээл" хувийн эмийн сан	2-р зэрэглэлийн эмийн сан	ЭСХ-15/10/1028	3 жил	2020-07-09 2023-07-09